

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 08-р сарын 28 өдөр

Дугаар №02/21

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2021 оны 8-р сарын 28-ны өдрийн 15.00 цагт эхлүүлсэн.

ХЭХурлын дарга: Б.Цолмон

Тооллогын комиссын дарга: Э.Тогосмаа

Тооллогын комиссын гишүүн: Д.Даваасүрэн /Монноос ХК Ерөнхий менежер/
С.Дэнсмаа нар ажилласан.

Хуралд оролцсон: Монноос ХК-ийн хувьцаа эзэмшигчид:

1. Д.Гиваапил- 69732ш
2. Адам Холдворсын итгэмжлэлээр П.Оюунбаяр-69824ш
3. С.Алимаа-14443ш
4. Марал импекс ХХК-ийн Д.Мөнхбат-69824ш
5. Шандас импекс ХХК-ийн итгэмжлэлээр М.Гөлгөө-20556ш

Монноос ХК-ийн нийтэд гаргасан 350877ш хувьцаанаас 244379ш хувьцаа эзэмшигч буюу 69,6%-ийн саналын эрх бүхий оролцогч оролцсноор хурлыг хүчинтэй гэж үзээд хурлыг 15 цаг 00 минутад эхлүүлж, 1 цаг 20 минутад багтаан явуулахаар тогтоов.

Хурлын дэгийг ХЭХурлын дарга Б.Цолмон танилцуулж, хуралд оролцогчдын 100%-ийн саналаар батлав.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмсаас, Монгол улсад илэрсэн тохиолдлын тоо өсч олон удаагийн хөл хорионоос, компани нь ямар ч орлогогүй болж, бусдад их хэмжээний өр үүссэн, банкинд төлөх өр зээл нэмэгдсэн, санхүүгийн хүндрэлийг, Компанийн хөрөнгийг худалдаж, хөрөнгийн эх үүсвэр гаргаж, банкны зээл бусад өр төлбөр барагдуулах, хөрөнгийг дагалдуулан газрын эзэмших эрхийг шилжүүлэх зөвшөөрөл олгосон тухай ТУЗ-ийн 07/21 тоот тогтоолыг хэлэлцэж батлах тухай.

2. Хурлаар хэлэлцсэн нь:

1. Монноос ХК-ийн 2021 оны хагас жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааг Х.Эрдэнэбаяр танилцуулаад дараах асуудлыг хуралд оруулав.
 - 2021 оны хагас жилийн санхүүгийн тайлангаар нийт өр төлбөр 16,8 тэрбум.₮ гарсан. Үүнээс банкны зээл 6,8 тэрбум.₮, бусад компаниуд, татварын өр төлбөр 10 тэрбум.₮ байгаа.
 - Хөл хориотой холбоотойгоор түрээслэгч компаниуд түрээслэхээ зогсоосон нь муугаар нөлөөлж, байр түрээслэх компаниуд одоогоор олдохгүй байна.
 - Үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаа болох ноос угаах шугамаа сэргээн засварласан ч захиалгагүйгээс үйлдвэрлэл явуулаагүй.
 - Ашиглахгүй байгаа мал эмнэлгийн байр, зоорь, 8 давхар оффисын барилга, бусад эзэмшил газруудын эрхийг худалдах замаар хөрөнгийн эх үүсвэртэй болох асуудлыг оруулж байна гэсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой санал, шүүмжлэл

Д.Гиваапил (хувьцаа эзэмшигч)- Компанийн санхүүгийн байдлыг хийсэн танилцуулгаас харлаа. Одоо үйлдвэрлэл явуулж, борлуулалтын орлого олоход хүндрэлтэй байгаа учраас өр зээлээ төлж чадахгүй байгаа юм байна. Өр зээлээ төлөхгүй удаад байвал өдрөөс өдөрт зээлийн хүү алданги гээд улам нэмэгдэх тул зарим хөрөнгийг худалдаж, мөнгөний эх үүсвэртэй болохыг дэмжиж байна.

Д.Мөнхбат(хувьцаа эзэмшигч)-Ковид дэлхий нийтэд тархснаас Монголын ихэнх компаниуд үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа явуулж чадахгүй, өр зээлэндээ баригдаж байгааг ойлгож байна. Гэхдээ компанийн удирдлагын зүгээс талбай түрээслэх замаар орлого олж байсан ч олон удаагийн хөл хорио тогтоосон, эдийн засгийн уналт зэргээс шалтгаалж, түрээслэгч компаниуд түрээсээ төлж чадахгүй гарцгаасан юм байна. Түрээсийн орлого олж чадахгүй бол зарим хөрөнгөө худалдах замаар мөнгө босгох хэрэгтэй.

Эрдэнэбаяр (гүйцэтгэх захирал)-Ковидын хөл хорионоос шалтгаалж, борлуулалтын орлого буурсан шалтгаанаар 8 түрээслэгч компаниуд талбай түрээслэх ажиллагаагаа зогсоосон. Талбай түрээслэх олон удаа зар тавьсан боловч түрээслэх компаниуд ирээгүй.

С.Алимаа(хувьцаа эзэмшигч)- Компанийн худалдах хөрөнгийн бүртгэлд байгаа үнэ хэд вэ?

Эрдэнэбаяр(гүйцэтгэх захирал)- Нийт 16 тэрбум.төгрөг.

С.Алимаа (хувьцаа эзэмшигч)-Компанийн хувьд түрээсийн орлого нэмэгдсэн ч банкны өр зээлээ төлөх хэмжээнд орлого олж чадахгүй нь тодорхой харагдаж байна. Иймээс компани өөрийн үндсэн үйл ажиллагаагаа сэргээж ноос, ноолуур угааж орлогоо нэмэгдүүлэх арга хэмжээг гүйцэтгэх удирдлага авах хэрэгтэй энэ талаар юу хийгдсэн бэ?

Эрдэнэбаяр(гүйцэтгэх захирал)-Үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаа болох ноос угаах шугамаа сэргээн засварласан одоо угаалга хийхэд асуудалгүй. Гэхдээ захиалга ирээгүйгээс үйлдвэрлэл явуулаагүй.

С.Алимаа (хувьцаа эзэмшигч)-барилга, зарим газрын эрхийг худалдаж байж, өр зээлээ төлөхийг дэмжиж байна. Хөрөнгөө худалдах компаниудын судалгааг хийсэн үү?

Эрдэнэбаяр(гүйцэтгэх захирал)- Хийсэн. Барилга худалдвал заавал газар эзэмших эрхийг шилжүүлэх шаардлагатай болоод байгаа. АПУ компани 1 газрын эрхийг худалдан авах санал өгсөн байгаа.

Гөлгөө(хувьцаа эзэмшигч)- Эдийн засгийн уналттай үед хичнээн үйл ажиллагаагаа сайжруулсан ч орлого нэмэгдэхгүй тул байгаа хөрөнгөө худалдаж, өр зээлээ барагдуулж, эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэй болохыг дэмжиж байна.

Д.Мөнхбат(хувьцаа эзэмшигч)- хөрөнгө худалдах үнийн саналыг сонсоё.

Эрдэнэбаяр(гүйцэтгэх захирал)-ТУЗ-аас ижил төрлийн хөрөнгийн зах зээлийн судалгааг өргөн хүрээнд хотын бүсчлэлээр явуулаад бүртгэлийн үнээс 2 дахин өндрөөр үнэлж худалдах үнийг 35 тэрбум.төгрөгөөр доод хэмжээг тогтоож өгсөн байгаа.

Д.Мөнхбат(хувьцаа эзэмшигч)- наад үнэ чинь доод үнэ болохоор үүнээс өндөр үнээр борлуулах ажлыг тусдаа төсөл гаргаад багийг томилж өгөөд ажлаа зохион байгуулах хэрэгтэй. Надад өөр санал алга ТУЗ-ийн шийдвэрийг дэмжиж байна.

2. **Хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, саналын дүнг гаргаж** Тооллогын комиссын дарга Э.Тогосмаа Хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

ХЭХурлаас шийдвэрлэсэн нь:

1. Монноос ХК-ийн хөрөнгийг худалдах, хөрөнгийг дагалдуулан газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай ТУЗ-ийн 07/21 тоот тогтоолыг дэмжив.
2. Монноос ХК-ийн барилгыг худалдаж, хөрөнгийн эх үүсвэр гаргах болон хөрөнгийг дагалдуулан газар эзэмших эрхийг шилжүүлэх нийт үнийн доод хязгаарыг 35,000,000,000 /Гучин таван тэрбум/ төгрөг байхыг дэмжив.

Тэмдэглэл бичсэн: Хурлын нарийн бичгийн дарга

Зөвшөөрсөн: Хурлын дарга



М.Тунгалаг

Б. Цолмон